



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРХОН АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ,
ЗАРДАЛ БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ОРА-2022/14-13-ШТА-ТД



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Ц.Нармандах

Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор В.Жавзмаа

Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оргилмөрөн

Утас: 70350757 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn



АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....	2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
Орхон аймгийн 2023 оны төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал.....	4
НЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦЭЖ БАЙГАА Ч ХҮРЭХ ҮР ДҮНГ ӨӨРЧЛӨХГҮЙ БАТАЛСААР БАЙНА.....	5
ХОЁР. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЗАРИМ ШАЛГУУРЫГ ХАНГУУЛААГҮЙ БАЙНА.....	6
ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА.....	8
ДҮГНЭЛТ:.....	10
ЗӨВЛӨМЖ.....	11



**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх хэсэг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2022 оны А/12 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Орхон аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2023 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Төсвийн төсөл нь улс, аймгийн тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эсэх;
- Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал тусгасан эсэх;

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг Аудитыг Орхон аймгийн 2021, 2022 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, 2023 оны төсвийн төсөл, төсвийн шууд захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.

Аудитад Орхон аймгийн Засаг даргын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн үзүүлэлтийг ашиглав.



Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Аймгийн Засаг дарга төсвийн шууд захирагчдын төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2023 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор В.Жавзмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, Г.Оргилмөрөн, аудитор Б.Азжаргал, Б.Бямбатогтох, Г.Даваасүрэн, Ж.Наранчимэг, О.Хэрлэнзаяа нар гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Эцэслэсэн боловсруулсан төсвийн төслийг хүлээн авснаас хойш 5-6 хоногт гүйцэтгэсэн болон аудитад ирүүлсэн төсвийн төсөл иж бүрэн бус байсан зэрэг нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл болж байна.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орхон аймгийн 2023 оны төсвийн бодлого, төлөвлөлтийн талаарх ерөнхий нөхцөл байдал

- Төсвийн төслийн танилцуулгад цар тахлын болон геополитикийн хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримтлах, Монгол Улсын 2023 оны төсвийн бодлогоор төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн дараах зорилтуудад чиглүүлэхээр тусгасан байна. Үүнд:
 - Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх;
 - Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих;
 - Нөөцийг оновчтой хуваарилах;
 - Эдийн засгийг тогтворжуулах.
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр ирэх онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:
 - Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах.
 - Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын нийлбэр дүнд шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах, тооцоолох ажлыг харьяа татварын албатай хамтран зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ханган ажиллах
 - Татварын ерөнхий хуулийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээс татварын өрд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх
- Аймгийн 2023 оны төсвийн урсгал зардлын төсөв боловсруулахад баримталсан зарчим
 - Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд төсөвт байгууллагын албан бичиг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэн, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх замаар холбогдох зардлыг хэмнэнэ. Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино хийх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал худалдан авах, хэвлэл захиалгын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй.
 - Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан дотоод албан томилолтын зардлыг нэмэгдүүлсний дагуу тооцож, бичиг хэргийн зардал болон Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглоогүй байгууллагуудын шатахууны зардлыг үнийн өсөлтийг тооцож, төсвийн төсөлд тусгах.
 - Засгийн газраас 2023 онд төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчийн үндсэн цалинг дээд шатлалаар нь тогтоож, суурь цалинтай болгох арга хэмжээг үргэлжлүүлэх.
 - Төрийн захиргааны албан хаагчийг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгоно. Мөн тухайн орон нутаг эдийн засгийн нөөцөө боломжит дээд хэмжээгээр ашигласан, орлогоо давуулан биелүүлсэн бол орон нутгийн удирдлага нь төрийн албан хаагчдынхаа цалинг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгох эрх зүйн орчныг бий болгоно. Энэ арга хэмжээний үр дүнд хөдөө, орон нутагт ажиллах төрийн албан хаагчийн цалин 2 дахин нэмэгдэх боломжтой болно.



- Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувийн давтамжтай 25 хүртэл хувиар олгодог одоогийн зохицуулалтыг шинэчилж, ажилласан жил бүрээр нь тооцон нэмэгдүүлнэ. Ингэснээр төрийн албан хаагч нь нэг жил ажилласан бол 1 хувь, хоёр дахь жилдээ ажиллавал 2 хувь гэсэн зарчмаар 25 жил ажилласан бол 25 хувийн нэмэгдэл авах ажилласан хугацаанаас хамаарсан цалингийн нэмэгдэл авдаг болно.
 - Үүний дагуу орон нутгийн төсвөөс төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар, төрийн бусад албан хаагчдын цалин хөлсийг 40 хувиар нэмэгдүүлэхээр тооцож, тус нэмэгдэлд 2,9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр Төсвийн тухай хуулийн 23.6, 23.8 дахь хэсэгт өөрчлөлт орж, аймгийн төсвийн татварын зарим орлого нь сумын татварын орлого байхаар хуульчилсан.
- Тус хуулийн дагуу 2023 оны төсвийн жилээс Баян-Өндөр сумын татварын орлогод дараах нэр төрлийн орлогуудыг шилжүүлж тооцохоор төсвийн төсөлд тусгасан байна. Үүнд:
- Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар
 - Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт
 - Үйл ажиллагааны орлого
 - Хөрөнгийн орлого
 - Хөрөнгө борлуулсны орлого
 - Шууд бус орлого
 - Үл хөдлөх эд хөрөнгийн татвар
 - Бууны албан татвар
 - Газрын төлбөр
 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж
- Аймгийн төсөвт 2022 оны 10 сарын байдлаар 167.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 109.5 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 14.7 хувиар давж биелэн, татварын бус орлогын төлөвлөгөө 27.0 хувиар тасарчээ. Нийт санхүүжилтийн 75.1 хувь буюу 134.6 тэрбум төгрөгийн зарцуулсан байна.

НЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦЭЖ БАЙГАА Ч ХҮРЭХ ҮР ДҮНГ ӨӨРЧЛӨХГҮЙ БАТАЛСААР БАЙНА

- 1.1 Аймгийн Засаг дарга Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1²-д заасан 4 жилийн стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, баталсан байна.
- 1.2 Төсвийн төслийг боловсруулахдаа 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг стратеги төлөвлөгөө, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг уялдаатай боловсруулжээ. Харин төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо, чанарын үзүүлэлтийг өөрчлөхгүй баталсан байна.
- 1.3 Төсвийн төсөлд тусгасан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу иргэдээс санал авч, байгууллагуудын санал, тооцооллыг нэгтгэн, ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөсөн байна.



1.4 Төсвийн төсөлд шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн 82 төсөл, арга хэмжээ нь хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн, тухайн жилд хэрэгжиж дуусах хугацаатай бөгөөд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасан *“Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах”* шалгуурыг бүрэн хангасан байна.

ХОЁР. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГУУЛААГҮЙ БАЙНА

2.1 Орхон аймгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан байна. Үүнд:

- Төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;
- Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах;
- Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.
- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;
- Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;
- Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах

2.2 Төсвийн төсөлд шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн 82 төсөл, арга хэмжээ нь хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн, тухайн жилд хэрэгжиж дуусах хугацаатай бөгөөд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасан *“Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах”* шалгуурыг бүрэн хангасан байна.

2.3 Аймгийн 2023 оны төсөвт шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 22 төсөл арга хэмжээ зураг төсөвгүй, 11 төсөл арга хэмжээ зураг хийгдсэн ч төсөвгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан *“Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”*, Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т заасан *“Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”*, 13.3.3-т заасан *“Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ”* заалттай нийцэхгүй байна. Үүнд:

Зураг төсөвгүй

- Орон сууцны хорооллын гэрэлтүүлэг хийх
- Уурхайчин баг 3-23-р байрны тоглоомын талбай тохижилт хийх
- Орон сууцны 6-р хорооллын 16,17-р байрны дунд тоглоомын талбай байгуулах
- Орон сууцны 6-р хорооллын 9,18-р байрны хэсэгт ус зайлуулах суваг шуудуу хийх
- Баянцагаан багт жишиг гудамж тохижуулах
- Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний хүрээнд шахмал түлшний үйлдвэрийн барилга барих /Орон нутгийн оролцооны зардал/
- Холбооны газрын үүдний хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шат, үүдний хэсгийн засвар хийх
- Найрамдал өндөрлөгийн шат болон тойрсон хэсгийн бэхлэгээний хананд засвар хийх
- ДГТ 3-2-р байрны сантехникийг шинэчлэх
- Баянцагаан багийн Соёлын төвийн засварын ажил хийх



- Баянцагаан баг ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /А хэсэг/
- Баянцагаан баг ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /Б хэсэг/
- 5-17 дугаар байрны авто зогсоолыг 5-18 дугаар байрны авто зогсоолтой хүзүүвч хийх
- Баян-Өндөр хотхоны 15-р байрны 1-р блок дээвэр засварлах
- Рашаант баг 15, 16, 17, 19, 20р гудамжинд орц гарц хийх
- Жаргалант сум 36-р точик, бөөн бургасны ногооны талбайг хашаажуулах, хуучин хашааг засварлах
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцжуулахад шаардлагатай КТП, ТП барих
- 4-25-ын авто зогсоол өргөтгөх шинэчлэлт хийх
- А1001 авто замын ногоон зурвасын усалгаанд худаг гаргах
- Тарлан толгойн таримал ойн төгслийн хамгаалалтын хашаа барих
- Жаргалант сумын тариалангийн талбайн хөрс хамгаалах хамгаалалтын хашаатай ойн зурвас байгуулах
- Баян-Өндөр уулын урт булгийн эхэнд хамгаалалтын хашаа бүхий мод тарьж, арчилж, ургуулах

Зурагтай боловч төсөвгүй

- Хотын төв зам дагуух гэрэлтүүлэг хийх
- Булаг багт камержуулалт хийх
- Эрдэнэ багт камержуулалт хийх
- Наран багт автобусны буудал, тохижилт хийх
- Орхон аймгийн төвийн хэсэгт дугуйн зам хийх
- Ирээдүйн одод сургуулийн спорт заалны өргөтгөл, үндсэн заалыг модон шалтай болгох
- Орон сууцны 6-р хорооллын 10-р байрны тоглоомын талбай сэргээн засварлах
- Баянцагаан багийн Вокзалын 3.4-р байрны орцны засвар хийх
- Баян-Өндөр хотхоны тоглоомын талбайг засварлах, тоглоом суурилуулах
- Дэнж багт орон сууцны орц засвар хийх
- Булаг багт жишиг гудамж байгуулах

2.4 Аймгийн 2023 оны төсвийн төсөлд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 31.1-д заасан шаардлагыг хангахгүй байна.

2.5 Төсвийн төсөлд төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тооцоог хавсаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 31.4-т заасан төсвийн төслийн бүрдлийг бүрэн хангуулаагүй байна.

2.6 Төсвийн танилцуулгад төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгасан хэдий ч тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулгыг иж бүрэн тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 32.2.11-д "... хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга" гэж заасантай нийцээгүй байна.

2.7 Аймгийн төсвийн төслийг боловсруулах явцдаа аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс олон нийтэд танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг авч, эрэмбэлсэн байна.



ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА

Төсвийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг тооцоогүй, 17.7 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээр тусгасан ч холбогдох журам, аргачлалыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна өсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна

3.1 Аймгийн нийт орлогын дүнг 126.7 тэрбум, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 111.5 тэрбум байхаар төлөвлөсний 93.9 хувийг татварын орлогоос, 6.1 хувийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцжээ.

3.2 Татварын орлогын 107.0 тэрбум, хүү, торгуулийн орлогын 1.5 тэрбум төгрөгийг Сангийн яамнаас хянасан дүнгээр тооцсон байна. Татварын орлогыг 2020 онд 65.9 тэрбум, 2021 онд 68.3 тэрбум, 2022 онд 159.9 тэрбум, 2023 онд 108.5 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

Хүснэгт 1 Төсвийн орлогын судалгаа

Төсвийн орлогын төрөл	/тэрбум төгрөг/			
	2020 оны батлагдсан төсөв	2021 оны батлагдсан төсөв	2022 оны батлагдсан төсөв	2023 оны төсвийн төсөл
Урсгал орлого	66.7	69.1	160.4	126.7
Татварын орлого	65.9	68.3	159.9	107.0
Татварын бус орлого	0.8	0.9	1.4	19.7
Тусламжийн орлого	48.0	47.2	10.7	111.5
Шилжих үлдэгдэл	19.5	15.8	10.3	15.4
Нийт орлого	134.2	132.2	182.4	253.6

Эх сурвалж: Орхон аймгийн 2020-2022 оны баталсан төсөв, 2023 оны өргөн барьсан төсвийн төсөл

3.3 Аймгийн 2023 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 56.2.2-т “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын төсвөөс аймгийн төсөвт 97.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд шилжих орлогыг 13.6 тэрбум төгрөг, 2022 оны төсвийн жилээс он дамжин хийгдэх хөрөнгө оруулалтын зардалд 8.4 тэрбум төгрөг, давсан орлогыг 5.0 тэрбум төгрөг, төсвийн хэмнэлтийг 2 тэрбум төгрөгөөр тус тус тооцжээ.

3.4 Орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 0.4 тэрбум, хөрөнгө борлуулсны орлогыг Уртын гол багт барьж буй “Орлогод нийцсэн орон сууц” төслөөс 17.7 тэрбум төгрөгөөр тооцжээ. Тус орон сууцны төслөөс орох орлогын тооцож, судалгаа хийсэн боловч журам, аргачлал боловсруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлснээр төсвийн төсөлд тусгах нь зүйтэй юм.

3.5 Аймгийн хэмжээнд бэлэн бус торгуулийн системээр 2022 оны 11 сарын байдлаар давхардсан тоогоор 22,896 иргэнд 1.5 тэрбум төгрөгийн торгууль ногдуулж, орон нутгийн төсөвт 16,920 иргэний 1.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрчээ. Иймд 5,976 иргэний 0.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, татварын орлого нэмэгдүүлэх боломж байна.

Төсвийн урсгал зардлыг бууруулах боломжтой байна

3.4 Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд Орхон аймгийн 2023 оны төсвийн орон нутгийн суурь зарлагыг 35.6 тэрбум төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 142.9 сая төгрөг байхаар баталсан байна.



3.5 Аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлага 253.6 тэрбум төгрөг, үүнээс орон нутгийн суурь зарлага 21.7 тэрбум, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлыг 70.8 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалтын зардал 5.3 тэрбум, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 7.4 тэрбум, Жаргалант сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 5.4 тэрбум, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 142.9 тэрбум төгрөг байхаар тооцжээ.

3.6 Аймгийн 2023 оны төсвийн төсөлд 2022 он батлагдсан төсвөөс цалин урамшууллыг 2.0 тэрбум, бичиг хэргийн зардлыг 0.07 тэрбум, дотоод, гадаад албан томилолтын зардлыг 0.07 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Энэ нь Засгийн газрын шийдвэр, Сангийн сайдын баталсан журамд нийцүүлэн цалин хөлсийг 40-60 хувь нэмж, албан томилолтын зардлын шинэчлэн тогтоосон тарифаар тооцоноос шалтгаалсан байна.

3.7 Хотын нийтийн тээврийн хөнгөлөлтөд 2020, 2021 онд жил бүр 1.2 тэрбум төгрөгийг төсөв баталж байна. Нийтийн тээврээр хөнгөлөлтэй үйлчлүүлэх иргэдийг бүртгэж, хянах тогтолцоо бүрдээгүйгээс үйлчилгээ үзүүлэгч аж, ахуй нэгжүүдэд татаас хэлбэрээр олгож ирсэн байна. Энэхүү зардалд их, дээд сургуулийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагч оюутнуудын нийтийн тээврийн хөнгөлөлтөд 0.4 тэрбум төгрөг төсөвлөгддөг боловч суралцагч оюутнууд нийтийн тээврийн хөнгөлөлт эдэлдэггүй байна. Их, дээд сургууль болон мэргэжлийн боловсролын суралцагч оюутнуудын нийтийн тээврийн хөнгөлөлтөд батлах 0.4 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой байна.

3.7 Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт шинээр эхлэх 4.5 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээ зураг төсөвгүй, 3.4 тэрбум төгрөгийн 11 төсөл арга хэмжээ төсөвгүйгээр тусган байх тул 7.9 тэрбум төгрөгөөр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах боломжтой байна.

Төсөл хөтөлбөрийн зардалд батлах жагсаалтад буй 9.5 тэрбум төгрөгийн 181 арга хэмжээний зардлын тооцоолол ирүүлээгүй бөгөөд бодит гүйцэтгэлийн анхан шатны баримтад шатахуун, сургалт, бичиг хэргийн зардлууд дийлэнх хувийг эзэлж байгаад болон зарим төрийн байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийг олгож байгаад дүн шинжилгээ хийж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарч Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөн ажиллах нь зүйтэй байна.

3.8 Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 15.3 тэрбум төгрөг байснаас тайлант онд 4.3 тэрбум төгрөгөөр буюу 27.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/тэрбум.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	1.7	11.0	2.2	11.1	0.5	3.2
- Төрийн сан	0.7	4.9	0.7	3.8	0.0	0.0
- Төсөл сан	0.2	1.4	0.2	1.1	(-0.004.)	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	12.6	82.7	16.4	84.0	3.8	24.8
Нийт дүн	15.2	100.0	19.5	100.0	4.3	27.9

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.9 Авлагын 84.0 хувь буюу 16.4 тэрбум төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, 11.1 хувь буюу 2.2 тэрбум төгрөгийг төсөвт байгууллагын, 3.8 хувь буюу 0.7 тэрбум төгрөгийг төрийн сангийн, 1.1 хувь буюу 0.2 тэрбум төгрөгийг төсөл сангийн авлага тус тус эзэлж байна. Төсөвт байгууллагын авлага 3.2 хувь буюу 0.5 тэрбум төгрөгөөр, ОНӨААН-ийн авлага 24.8 хувиар буюу 3.8 тэрбум төгрөгөөр өсөж, төсөл сангийн авлага буурсан байна.

Тайлант онд ӨЭМТ-үүдийн авлага 0.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс шалтгаалжээ.



3.10 Авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулаагүй, насжилт өндөртэй, барагдуулах боломжгүй, шийдвэрлэгдэхгүй байх үр дагавартай авлага оршин байгаад анхаарахаар байна. Үүнд:

- 1996-1997 онуудад дампуурсан ХОТШ, даатгал банктай холбоотой орон нутгийн 9 байгууллагын 134.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна.
- Их шүтээн цогцолборын 68.6 сая төгрөгийн он дамжсан авлага

3.11 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд арилжааны 3 банканд 0.6 тэрбум төгрөгийн зээлийн авлагын гэрээг дүгнэж, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.12 Орон нутгийн өмчит газруудыг өөрийн орлогоор бус орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, 3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд хууль журам, дүрэмд нь нийцүүлэн ажиллуулах, эсвэл тухайн чиг үүргийг гүйцэтгэдэг төсвийн байгууллагад нэгтгэж ажиллах талаар судалгаа тооцоолол хийх шаардлага байна.

3.13 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/188 дугаар захирамжаар баталсан “Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 03-р сарын 14-ний өдрийн А/122 дугаар захирамжаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, аймгийн Засаг даргын дэргэдэх 23 агентлаг, 2 сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд ХШҮ-г зохион байгуулжээ.

Захиргааны байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн дүнгийн танилцуулгыг ажлын хэсгээс нэгтгэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний дүгнэлтийг үндэслэн агентлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газарт цаашид анхаарч ажиллах, ажлаа эрчимжүүлэх талаар зөвлөмжийг хүргүүлжээ. Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ажил сайжруулах чиглэлээр удаа дараалан өгөгдсөн ХШҮ-ний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй албан хаагчдад хариуцлага тооцох арга хэмжээг авах, хариу мэдэгдэх шийдвэр гаргасан байна.

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14.2.11-т “төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах” гэж заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээг 3-5 жил тутамд хийх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Орхон аймгийн 2023 оны төсвийн төслийг Төсвийн тухай хууль, холбогдох журам, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн, төсвийн тусгай шаардлагын дагуу боловсруулсан байна.

2. Төсвийн төсөл аймгийн хөгжлийн бодлогод нийцэж байгаа ч төсвийн эрх захирагч нарын хүрэх үр дүнг өөрчлөхгүй баталсаар байна.



3. Төсвийн төсөл Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг бүрэн хангаагүй байна.
4. Төсвийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг тооцоогүй, 17.7 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэхээр тусгасан ч холбогдох журам, аргачлалыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.
5. Төсвийн төслийн тусгай шалгуурыг хангуулаагүйгээс 8.3 тэрбум төгрөгөөр зардал бууруулах боломжтой байна.
6. Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улс орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өгсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдал давтагдсан хэвээр байгаа нь өмнөх аудитын дүгнэлт, зөвлөмжийн ач холбогдол, үр нөлөөг бууруулж, төсвийн сахилга хариуцлага шат шатандаа алдагдаж байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Аймгийн 2023 оны төсвийн төсөл батлахтай холбогдуулан “Орлогод нийцсэн орон сууц” төслөөс орох орлогын тооцоололтой холбоотойгоор тус орон сууцыг худалдан борлуулж, орлого төвлөрүүлэх журам, аргачлал хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянаж, батлах;

Аймгийн Засаг даргад:

2. Төсвийн төсөлд төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, үр дүн гүйцэтгэлийг харгалзан, өөрчлөлтийг тусгаж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах;
3. Төсвийн хөрөнгөөр боловсруулсан барилга, байгууламжийн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, төсвийн төлөвлөлтөд ил тод, нээлттэй ашиглах боломж бүрдүүлэх;
4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх ажлыг шат шатанд зохион байгуулж, биелэлтийн талаарх мэдээллийг 2022 оны 12 дугаар сарын 20-нд багтааж Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.